



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Зөрчлийн хэрэг)¹

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД АШИГЛАГДАХААС БУСАД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ОРУУЛСАН ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРЧ, ЖИЛ ТУТМЫН ТУХАЙН ЦАГ ХУГАЦААНЫ ДОТОР ҮЗЛЭГТ ХАМРУУЛНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь давж заалдах шатны шүүхийн магадлал болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ДШМЗ/322

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Зөрчилд холбогдогч нь 2025 оны 09 сарын 08-ны өдөр Гадаад хэргийн яамны үрд талын замд өөрийн өмчлөлийн автомашиныг жолоодон явахдаа Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.2 дахь заалтад заасан “...хуульд заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэгт оруулаагүй” тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтан 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ... дугаартай шийтгэлийн хуудсаар зөрчилд холбогдогчийг Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 14.7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.2 дахь заалтад² зааснаар 50 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 50.000 төгрөгөөр торгожээ.
2. Зөрчилд холбогдогчоос “миний жолоодож явсан тээврийн хэрэгсэл нь 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр буюу хугацаа дуусаагүй байхад оношилгоонд орж тэнцсэн. Миний бие тээврийн хэрэгслийг жилд нэг удаа үзлэгт хамруулах

¹ Зөрчлийн хэргийн материалаас

² Шинэчлэн найруулсан 2017 оны Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Хуульд заасан журмын дагуу”, 10.2 дахь хэсэгт “техникийн хяналтын үзлэгт оруулаагүй”



үүрэгтэй бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор автомашинаа техникийн үзлэгт хамруулах үүргийг хүлээнэ. Гэтэл энэ хугацаа дуусаагүй байхад ийнхүү торгож буй нь хууль бус тул шийтгэлийг хүчингүй болгож өгнө үү” гэсэн агуулга бүхий гомдлыг анхан шатны шүүхэд гаргажээ.

3. **Анхан шатны шүүхээс** зөрчилд холбогдогчийн гаргасан “шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох тухай” гомдлыг хангахаас татгалзаж эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
4. Зөрчилд холбогдогч давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо “Анхан шатны шүүхийн шийтгэвэрт Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам”-ын 4.3 дахь хэсэгт “Иргэн, хуулийн этгээд нь нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг хагас жил тутамд, бусад тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулах үүрэгтэй”³ гэж заасныг өмнөх онд оношлогоонд орсон хугацаагаар тооцно гэж тайлбарласан байна. Дээрх журамд тогтсон хугацаа л гэсэн болохоос өмнөх оны оношлогоонд орсон үеэс гэж тодорхойлоогүй байхад анхан шатны шүүх дээрх сайдын хэм хэмжээг буруугаар тайлбарласан тул надад оногдуулсан шийтгэл бүхий торгуулийг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.
5. **Давж заалдах шатны шүүхээс** Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн талаар нотолбол зохих байдлуудыг бүрэн шалгаж, тодруулснаас гадна оролцогчдын эрхийг хасаж буюу хязгаарласан, эсхүл бусад байдлаар шүүхийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхүйц зөрчил гараагүй байна. (2)
6. Жолооч тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд техникийн үзлэг, оношлогоонд хамруулах үүрэгтэй ба зөрчилд холбогдогч нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр техникийн хяналтын үзлэгт оруулсан байх бөгөөд тухайн хугацаа хуульд заасан журмын дагуу 2025 оны 08 сарын 07-ны өдөр дууссан гэж тооцсон нь зүйтэй. (8)
7. Эрх бүхийн албан тушаалтан нь Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.2 дахь заалтад зааснаар зөрчилд холбогдогчид торгох шийтгэл оногдуулсан нь хууль зүйн үндэслэлтэй, зөрчилд холбогдогчийн гаргасан зөрчилд тохирсон байх тул анхан шатны шүүхийн шийтгэврийг хэвээр үлдээж, зөрчилд холбогдогчийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. (9, 10)

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390197569401>



---o0o---